



ГОВЬСУМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 07 өдөр

Дугаар 1181

Шивээговь сум

Г Малын гоц халдварт шүлхий өвчнөөс
урьдчилан сэргийлэх дархлаажуулалт
хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны өрөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, 6.5, 6.6, 9 дүгээр зүйл, аймгийн Засаг даргын 2019 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн “Дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай” А/251 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Суманд мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг тухайн өвчинд мэдрэг мал, амьтанд 2020 оны 05 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн зохион байгуулсугай.

2. Урьдчилан сэргийлэх дархлаажуулалт хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн дарга:

Б.Баасанбат

(Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Нарийн бичгийн дарга:

Ш.Буяннэмэх

(Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч)

Гишүүд:

А.Нандинцэцэг

(1 дүгээр багийн Засаг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

А.Энхмаа

(2 дугаар багийн Засаг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

А.Цэрэндолгор

(Малын эмч)

3. Тарилганд хамрагдах малын тоог хавсралтаар баталсугай.


4. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийг мэргэжил арга зүй, удирдлагаар хангаж, технологийн мөрдөлтөнд хяналт тавьж ажиллахыг сумын Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч /Ш.Буяннэмэх/-д, урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын

421200225

төвүг мал, амьтан өмчлөгчид зарлан мэдээлж, малчдын малыг бүрэн хамруулахыг 1, 2 дугаар багийн Засаг дарга наарт тус тус үүрэг болгосугай.

5. Дархлаажуулалтыг чанартай, стандартын дагуу хийж дуусгахыг малын эмч /А.Цэрэндолгор/-д даалгасугай.

6. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Баасанбат/-д үүрэг болгосугай.



Сумын Засаг даргын оны р
сарын -ны өдрийн дугаар
захирамжийн хавсралт



ДАРХЛААЖУУЛАЛТАНД ХАМРУУЛАХ МАЛЫН ТОО

№	Сумын нэр	Хамрагдах малын тоо			
		үхэр	хонь	ямаа	бүгд
1	Шивээговь	2209	25437	25389	53035